



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ Багшийн мэргэжлийн зэрэг олгох, хасах журам батлах тухай

[БШУС-ын 2013 оны А/305-р тушаалаар хүчингүй болсон](#)

2008 оны 11 сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот Дугаар 73 Бага, дунд боловсролын тухай хуулийн 21.4, 21.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь: 1. “Багшийн мэргэжлийн зэрэг олгох, хасах журам”-ыг хавсралтаар баталж, 2008 оны 1 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй. 2. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан 2008 мэргэжлийн зэргийн хүчинтэй байх хугацаа нь дууссан багш нарт мэргэжлийн зэргээ хамгаалах, ахиулах болон мэргэжлийн зэрэг шинээр авах багш нарын хүсэлтийг 2009 оны 2 дугаар сард багтаан шийдвэрлэхийг Бага, дунд боловсролын газар (Н.Энхбат), аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар, сургууль, цэцэрлэг, Гэгээрлийн төвийн удирдлага нарт үүрэг болгосугай. 3. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Бага, дунд боловсролын газар (Н.Энхбат), аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар, сургууль, цэцэрлэг, Гэгээрлийн төвийн удирдлага, журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж ажиллахыг Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (М.Баасанжав), багшийн мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгоход шаардагдах зардлыг жил бүрийн боловсролын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн газар (С.Наранцогт)-т тус тус даалгасугай. САЙД Ё.ОТГОНБАЯР Улсын бүртгэлийн 2008 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 2961 дугаарт бүртгэсэн.